



НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ ТЭЭВРИЙН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2018 оны 01 сарын 10 өдөр

Дугаар 8/03

Улаанбаатар хот

Нийтийн тээврийн үйлчилгээний чиглэлийн гаралтыг түр хугацаагаар хасах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь хэсэг, Захиргааны ерөнхий хуулийн 57 дугаар зүйлийн 57.1 дэх хэсэг, Автотээврийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.4 дэх заалт, Нийслэлийн Засаг даргын 2016 оны А/928 дугаар захирамжаар батлагдсан Нийслэлийн Тээврийн газрын “Дүрэм”-ийн 2.5.3 дахь заалтыг тус тус үндэслэн **ТУШААХ** нь:

1. Нийтийн тээврийн үйлчилгээг гүйцэтгүүлэх гэрээний үүргийг тээвэрлэгч тал биелүүлээгүй тул Ч:З “Зүүн салаа-Халдварт” чиглэлд Нийтийн тээврийн үйлчилгээ эрхлэн гүйцэтгэдэг “Автобус нэгдэл” ХХК-ийн 2 гаралтын үйлчилгээг 2 сарын хугацаатайгаар хассугай.

2. Дээрх өөрчлөлтийг 2018 оны 01 дүгээр сарын 13-ны өдрөөс мөрдөх үйлчилгээний цагийн хуваарийг боловсруулж нэгдсэн даалгаварт тусгахыг Тээврийн төлөвлөлт, технологийн хэлтэс /Д.Галбадрах/-т, үйлчилгээ эрхлэгч аж ахуйн нэгж байгууллагатай байгуулсан гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулахыг Захиргааны удирдлага, санхүүгийн хэлтэс /Ц.Мөнхбат/-т, тухайн чиглэлийн үйлчилгээг зохион байгуулж, зохицуулалт хийх, хэвийн ажиллагааг хангуйж ажиллахыг Зорчигч тээврийн үйлчилгээний хэлтэс /Э.Баярт/-т тус тус даалгасугай.

3.Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Орлогч даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч /Х.Булгаа/-д үүрэг болгосугай.

A red rectangular stamp with vertical columns of text and a large handwritten signature 'Д.ОТГОНБААТАР' across it. The stamp contains the following text:

ДАРГА
Д.ОТГОНБААТАР
1115108253 2117428

Хянасан

Соловсруулсан

Урзийбаатар

Л.. жүрь бичсэн

Доржмыадаа